

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
СТРАТЕГИ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСТ
САЛБАРЫН СУДАЛГАА МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

2020 оны 01 дүгээр сарын 08 өдөр

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1.3.1, 2.1-д заасны дагуу **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хүнд үйлдвэр Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын, Газрын тосны хэлтэст Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, зах зээлийн судалгаа, статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэний** сонгон шалгаруулах зарыг олон нийтэд мэдээлж байна.

Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасны дагуу зохион байгуулж явуулна.

Нэг. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх иргэнд тавигдах болзол

- Монгол Улсын иргэн байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан байх.

Хоёр. Албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Албан тушаалд тавигдах тусгай шаардлага: Дэс түшмэл, ТЗ-07		
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Салбарын инженер, санхүү-эдийн засаг /031101/, олон нийттэй харилцах ажил /041402/	
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - салбарын статистик мэдээлэл, тооцоо судалгааны мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй; - салбарын статистик мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэн санал, зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутаг, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран

		<p>хэлэлцүүлэг, хурал, семинарыг зохион байгуулах, оновчтой санал, дүгнэлтийг гаргуулах;</p> <p>- бусад.</p>
	Багаар ажиллах	<p>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</p> <p>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох ;</p> <p>- хариуцсан ажилүүргийнхувьдбүтээлч, санаачлагатайажиллах;</p> <p>- багаар ажиллах чадвар, хамт олноо дэмжих;</p> <p>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажил хэрэгч, харилцааны соёлтой, ёс зүйтэй байх;</p> <p>- хамт олны саналыг сонсох, санал солилцох, эргэх холбоотой байх;</p> <p>- бусад.</p>
	Бусад	<p>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</p> <p>- компьютерийн хэрэглээний програм, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</p> <p>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;</p> <p>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;</p> <p>- харилцааны соёлтой, ёс зүйтэй байх;</p> <p>- хамт олны саналыг сонсох, санал солилцох, эргэх холбоотой байх;</p> <p>- шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх</p> <p>- бусад.</p>

Гурав. Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг:

Уг ажлын байрны сонгон шалгаруулалтад Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид болон төрийн албаны нөөцөд байгаа иргэд бүртгүүлэх боломжтой бөгөөд "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 2.2-т заасан дарааллын дагуу нөхнө. *(Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид бүртгүүлээгүй тохиолдолд нөөцөд байгаа иргэдээс сонгон шалгаруулна. Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид бүртгүүлсэн тохиолдолд нөөцөд байгаа иргэд сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй болохыг анхаарна уу.)*

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт заасны дагуу ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн албан хаагчийг "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам"-аар шатлан дэвшүүлж болно.

- Төрийн албан хаагчийн анкет “А хэсэг” болон “Б хэсэг”;
- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;

- Иргэний үнэмлэхийн хуулбар, эх хувийн хамт;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн хуулбар, эх хувийн хамт; /Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах/
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар, эх хувийн хамт; /албан тушаалын тодорхойлолтын туршлагын шаардлагад заасны дагуу туслах түшмэлийн ангилалд ажилласныг нотлох тушаал, шийдвэрийг холбогдох байгууллагаас хуулбарлан авч ирэх бөгөөд байгууллагын “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулах;
- “4 х 6”-ийн хэмжээний 2 хувь цээж зураг;
- 2017 - 2019 оны төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас. /холбогдох байгууллагаас авч ирэх бөгөөд байгууллагын “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт;
- Шалгалтын үйлчилгээний зардал.

Дээр заасан баримт бичгийг дутуу бүрдүүлсэн, зохих ёсоор бүрдүүлээгүй иргэнийг бүртгэхгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх

Сонгон шалгаруулалтад оролцох төрийн жинхэнэ албан хаагчийн хүсэлт болон бүрдүүлсэн баримт бичгийг **Засгийн газрын II байр, УУХҮЯ-ны II давхарт 203 тоотод 2020 оны 01 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд** 09:00-17:00 цагийн хооронд комисс хүлээн авна.

Сонгон шалгаруулалтад бүртгүүлэх болзлыг хангаж, холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн албан хаагчийг бүртгэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа гаргах бөгөөд болзол хангаагүй бол энэ тухай шалтгааныг мэдэгдэнэ.

Тав. Сонгон шалгаруулалтын хуваарь

Сонгон шалгаруулалтыг **2020 оны 01 дугаар сарын 24-ний өдөр** дараах агуулгын хүрээнд зохион байгуулна.

1. Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг;
2. Дүн шинжилгээ хийх чадвар
3. Асуудал шийдвэрлэх чадвар;
4. Монгол хэлний ярианы болон бичгийн чадвар;
5. Удирдан зохион байгуулах чадвар;
6. Манлайлах чадвар;
7. Багаар ажиллах чадвар;
8. Оролцогчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин.

Төрийн жинхэнэ албаны туслах түшмэлийн сонгон шалгаруулалтад оролцох иргэн “Иргэний цахим үнэмлэх” биедээ авч ирэхийг анхаарна уу.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
Холбоо барих утас: 51-264054, 51-260864

